



“Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” (АДАПТ) төсөл

ТАТМЫН ОЙЖУУЛАЛТ, ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖИЛ ХИЙХ ТОХИРОМЖТОЙ ТАЛБАЙ СОНГОХ, АНХААРАХ АСУУДАЛ

Төслийн Ойн менежментийн үндэсний зөвлөх, Байгаль Орчны гавьяат ажилтан, Ойн аж аухйн инженер, Доктор (Ph.D), профессор **Д.Энхсайхан**

Бургас ашиглах тухай

- Бургасны янз бүрийн зүйлийг хүмүүс өөрсдийн ахуйн хэрэгцээндээ өргөн хэрэглэж ирсэн.
- Увс, Баян-Өлгий, Ховд, Завхан зэрэг аймгуудад бургасаар маш бат бөх гэрийн унь, хана зэргийг хийж ашигладаг. Мөн мод, холтос, гөлөг, навч зэргийг ардын эмнэлэгт хэрэглэж ирсэн юм.
- 1990 онд онд Баян-Өлгий аймаг байгалийн бургаснаас бэлтгэж жилд 100 гаруй гэрийн мод бэлтгэдэг байсан юм. Баян-Өлгий аймаг бургасыг өөрийн нутгаас гадна Увс, Хөвсгөл аймгийн нутгаас бэлтгэж хэрэглэдэг байв.
- 1990 оны үеэс Баян-Өлгий аймагт 250 га бургасны плантац байгуулж тэндээсээ бургас бэлтгэж хэрэглэж байлаа.
- Хэнтий аймагт дээр үеэс бургасыг мөн ашигладаг байсан Үүнд: уурганы үзүүр шилбүүр, савар г.м.

Татмын ойн нөхөн сэргээлт


- Одоогийн байгаа бургасан шугуйг цаашид хэрхэн нөхөн сэргээж ургуулах асуудал чухал байна;
- Бургасан шугуйг ойжуулах гол асуудлын нэг бол ургуулах бургасны зүйлийг зөв сонгох юм;
- Ойжуулалтын зориулалтаар ургуул ургуулах бол Шүүдэрт бургас, Гурван дохиурт бургас, Саваан бургас , Хуурамч таван дохиурт бургас, Цагаан бургас, Бэббийн бургас, Ледебурын бургас, Миабейн бургас тохиромжтой;
- Татмын ойн голын дагуу ойжуулалт хийх бол тухайн нутагт байгаа бургасны зүйлийг ургуулах хэрэгтэй.

Бургасыг тарих зориулалт

- Татмын бургасан шугуйг ойжуулах;
- Бургасны үйлдвэрлэлийн плантаци байгуулж түүхий эд бэлтгэхэд;
- Гол, мөрөн, булаг шанд, баян бүрдийг хамгаалахад;
- Ойн зурвас байгуулахад;
- Хот, суурин газрыг ногооруулахад;
- Зуслан, хувийн эзэмшлийн хашааны дотор амьд хашаа байгуулахад;
- Элс, гуу жалга, эргэ бэхлэх зориулалтаар зэргээр өргөн ашиглаж болно.

Ойжуулалтанд хэрэглэх суулгацыг бэлтгэх

Ойжуулалт хийх ажлын талбайг сонгож авсны дагуу тухайн нутагт ямар зүйлийн бургас ургаж байгааг тогтоож тэр бургаснаас мөчир бэлтгэн тайраадас болгон бойжуулах талбайд ургуулж 2-дээш настай суулгацыг шилжүүлэн ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэнэ.



Бургасны саваа мөчир, бэлтгэсэн тайраадас



- Тайраадас бүр 8-аас доошгүй ширхэг нахиатай байвал зохино.
- Бургасны модожсон мөчрийн I, II зэргийн тайраадсыг тусгай зориулалтын бургасны плантаци байгуулах, гол мөрөн, ууланд ойжуулалтын ажил хийхэд шаардлагатай бургасны суулгац бэлтгэхэд зориулж ургуулахад илүү тохиромжтой.
- Бэлтгэсэн саваа мөчрийг тусгайлан хадгалсан зоориноос гарган авч тэдгээрийг тарихаас нэгээс, хоёр долоо хоногийн өмнө тайраадас болгон хэрчиж бэлтгэнэ.
- Саваа мөчрөөс тайраадас бэлтгэхдээ мөчрийн хайч буюу тусгайлан суурилуулсан мөчир хайчлагчаар хэрчинэ.
- Тайраадасны бүдүүн нь 0.6-1.8 см байх ба саваа мөчрийн v доод, дунд хэсгээс бэлтгэх нь илүү тохиромжтой байна






Ойжуулалтанд хэрэглэх суулгацыг бэлтгэх:

Ойжуулалт хийх ажлын талбайг сонгож авсны дагуу тухайн нутагт ямар зүйлийн бургас ургаж байгааг тогтоож тэр бургаснаас мөчир бэлтгэн тайраадас болгон бойжуулах талбайд ургуулж 3-4 настай суулгацыг шилжүүлэн ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэнэ.


Бургасны суулгацыг суулгах:

- Суулгацыг намар модны өсөлт зогсохоос эхлэн хөрс хөлдөх v хүртэл, хавар модны шүүс хөдлөх хүртэл хугацаанд ухаж авч бэлтгэх;
- Суулгацыг ухаж авахдаа үндэсний систем, иш, мөчрийг v гэмтээхгүй байх;
- Суулгацын үндэс гэмтээгүй сахлаг байх;
- Ойжуулалт, элсний нүүлт хамгаалах, бургасны үйлдвэрлэлийн v плантаци байгуулахад 2-3 настай суулгац тохиромжтой;
- Бургасны суулгацыг тээвэрлэхдээ машины тэвшинд чийгтэй шороо, үртэс асгаж үндсийг далд ортол булж услах;
- Тээвэрлэх хугацаанд тогтмол чийгтэй байлгах хэрэгтэй.

- Суулгалтын хугацаа нь тухайн нутгийн байгаль цаг уурын нөхцлөөс ихээхэн хамаарна. Бургасны суулгацыг хавар 4-р сарын 25-аас 5-р сарын 20-нд, намар 9-р сарын 30-аас 10-р сарын 10 хүртэл хугацаанд суулгана.
- Суулгацыг суулгахад эгнээ ба ургамал хоорондын зайг зөв тогтоож шулуун шугаманд байрлуулна.
- Бургас суулгах суулгацны үндэсний хүзүүг газрын гадаргуугаас доош 10-15 см гүнд тарина.
- Бургасны суулгацыг суулгасны дараа түүний гол гуврыг газрын гадаргуугаас дээш 10-20 см-т цэцэрлэгийн хайчаар тайрч үлдсэн угийг тосон будгаар будна.



Бургасны суулгацыг нүхэнд суулгах арга




Бургасны суулгацыг суулгах схем

Ашиглалтын зориулалтаас хамаарч бургасны суулгацын га-д байх тохиромжтой схемыг тогтоох шаардлагатай.

Бургасны суулгацыг суулгах схем:

1. Бургасны суулгах талбайд ургамал хооронд 1.0 м, эгнээ хооронд 1.5 м.
2. Бургасны суулгах талбайд ургамал хооронд 1.5 м, эгнээ хооронд 2.0 м.
3. Бургасны суулгах талбайд ургамал хооронд 1.5 м, эгнээ хооронд 3.0 м.
4. Бургасны суулгах талбайд ургамал хооронд 2.5 м, эгнээ хооронд 3.0 м.
5. Бургасны суулгах талбайн ургамал хооронд 3.0 м, эгнээ хооронд 3.0 м-ээр тус тус байрлуулна.

Бургасны суулгацыг байрлуулах схем



Усалгаа

- Ойжуулалтын бургас суулгах талбайд суулгац суулгахаас 3-4 хоногийн өмнө ухсан нүхийг нэг удаа усална. Суулгацыг суулгасны дараа 35-40 см гүнд нэвчилж услана.
- Ургамал ургалтын хугацаанд Ойт хээр, Алтай, говь, хээрийн бүсэд 5 ба 6-р сард 10-14 хоногийн зайтай, 7 ба 8 сард 14-16 хоногийн зайтай 2 удаа услана. 9-р сард нэг удаа усална.
- Усалгааны норм нь нэг га-д 500-700 м³ ус орохоор тооцно.
- Усалгааны норм, услах хугацаа нь тухайн жилийн хур тунадасны хэмжээнээс хамаарч өөрчлөгдөхийг анхаарах хэрэгтэй.
- Ургамал ургалтын нийт хугацаанд 10-13 удаа усалгааг хийнэ.

Тарьсан бургасыг хамгаалах:

- Ойжуулалт бургасаар модонд хортон шавж илэрвэл мэргэжлийн байгууллага, хүмүүсээс тусламж авах.
- Суулгасан бургасыг туулай болон бусад мэрэгчид идэх гэмтээх, мал гэмтээхээс хамгаалж хаших шаардлагатай.



**Татмын бургасан шугуйд цэвэрлэгээний
ажлыг хийх талбайг сонголт, анхаарах
асуудал**

Бургасан шугуйн ашигт чанарыг нэмэгдүүлэх сайн чанарын мод ургуулах, түймрийн аюулаас хамгаалах, гол, мөрний ус, хөрс хамгаалалтын чадавхийг дээшлүүлэх зорилготой цэвэрлэгээний ажлыг тогтмол явуулах. Үүний тулд дараах зүйлийг анхаарах нь чухал. Үүнд:

1. Бургасан шугуйд цэвэрлэгээний ажил явуулах талбайн хэмжээг ойн зохион байгуулалтын материалыг үндэслэн улс, орон нутгийн ой хариуцсан төрийн төв байгууллагаас тогтоож гаргана.
2. Бургасан шугуйд цэвэрлэгээ ажил явуулах төлөвлөгөөг жил бүр гаргаж, холбогдох ой хариуцсан байгууллагаар батлуулж хэрэгжүүлнэ.
3. Бургасны цэвэрлэгээний ажил явуулах талбайг аймаг, орон нутагт ойжуулалт хариуцсан мэргэжилтэн, техникч нар сонгож буссолийн зураг авалт хийж талбайг тусгаарлах ба технологийн карт үйлдэнэ.
4. Цэвэрлэгээний ажил явуулсан талбай тус бүрт тусгай журнал хөтөлнө. Үүнд: талбайн хэмжээ, гарсан модны нөөц, ажил гүйцэтгэсэн он, сар, өдөр зэргийг бичнэ.
5. Бургасан шугуйд цэвэрлэгээний ажил явуулсан талбайд дуусгаврын актыг хөтлөж батлуулна.

Бургасан шугуйд цэвэрлэгээний ажил явуулахдаа дараах үндсэн зарчмыг баримтлана.

1. Бургасан шугуйд хийх цэвэрлэгээний ажлыг 50 дээш наснаас эхлэнэ.
2. Цэвэрлэгээний ажлыг эхний хийсэн хугацаанаас хойш 3 жилд, дараа нь 5- 8 жилд давтан хийнэ.
3. Бургасан шугуйд цэвэрлэгээ хийсний дараа га талбайд 1000-1200 ширхэг бут байхаар бодож үлдээж зохицуулна.
4. Цэвэрлэгээний ажлын явуулах нийт хугацаанд 100 хувьд тайралт хийнэ. Эхний удаа бүх модны 25-40 хувийг дараачийн жил үлдсэн модны 75-60 хувийн тайралт хийж гүйцэтгэнэ. Гэхдээ нэг бутны 1/3 хувиас хэтрүүлэхгүйгээр зохицуулан ттаналт хийнэ. Цэвэрлэгээний ажил хийсний дараа явуулсны дараа үлдсэн бургас нь ишний хажуу талаас бус харин титмийн оройн хэсэгтээ их гэрэл авч байхаар тооцно.


1. Бургасны шугуйдцэвэрлэгээний ажил явуулахад юуны өмнө өсөлт, хөгжилт, ишний хэлбэр, чанар сайтай шилмэл модыг үлдээнэ.
2. Арчилгааны огтлолтоор юуны өмнө өсөлт, хөгжилт, ишний хэлбэр муутай, өвчин, хортон, түймэрт өртсөн, хэт шигүү ургасан, өтөлсөн иш, салаа мөчиртэй бургасыг тайрна.
3. Цэвэрлэгээний ажил явуулсны хойно үлдсэн модыг цаашид ямар зорилгоор ашиглахаас хамааран аль болох өндөр, бүдүүн, шулуун иштэй юм уу, эсвэл нэг ишийг тодорхой өндөрт оройноос нь тайрч олон салаа найлзуур мөчир ургуулах зэрэг аж ахуйн хэрэгцээг хослуулбал илүү тохиромжтой.
4. Хатаж, өтөлсөн ишийг газрын гадаргаас дээш 20-30 см өндөр хожуул үлдээн тайрна.

Цэвэрлэгээний ажлаар бургасны өсөлт, хөгжилтийг гол болгохын хамт талбайд буй модны үлдэгдэл усны үерээр хаягдсан хог новш зэргийг цэвэрлэж, ил гарсан үндэсний хэсгийг шороогоор дарж хатаж гэмтэхээс хамгаална. Энэхүү бургасны цэвэрлэгээний ажлыг зөв хийснээр бургасан шугуйн бургасны нөөц нэмэгдэх, түймэр, хортон шавж, өвчинд нэрвэгдэхгүй тэдгээрийн тэсвэрт чадвар нь нэмэгддэг сайн талтай юм.

Татмын ойн бургасан шугуйд цэвэрлэгээний ажил хийх талаар гэрэл зургаар тайлбарлан оруулбал:

Бургасан шугуйд цээрлэгээ хийх шаардлага хангасан бургас.





Татмын ойд ургаж байгаа хөгширсөн бургас. Энэ бургас модонд цэвэрлэгээний ажил хийнэ. Эхлээд нэг бутны 25-40 хувьд тайралтын ажил хийнэ.

Тайралтыг жигд хийх хэрэгтэй. Нэг доороос бөөнөөр авч тайралт хийж болохгүй.

Хэрлэн голын дагуу тархан ургасан татмын бургасан шугуй цэвэрлэгээний ажил хийхэд шаардлага хангасан байна. Хатсан хэсгийг эхний ээлжинд цэвэрлэнэ.





Байгальд ургаж байгаа бургасны бут. Эхний ээлжинд 25-40 хувийг тайралт хийнэ. Эхлээд хатсан, өвчин хортонд иддэгдсэн салаа мөчрийг тайралт хийж авна.

Бургасны модонд тайралт хийсэн бургаснысаваа мөчрөөр янз бүрийн ахуйн хэрэгцээнд ашиглах эдлэл хийж ашиглана.

**Бургасан шугуйд цэвэрлэгээ
хийж байна.**



Цэвэрлэгээ хийсний дараа.





Анхаарал хандуулсанд баярлалаа